



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 12/33

Номгон

Гурванбулаг сумын Засаг даргын
Тамгын газрын үйл ажиллагааг
сайжруулах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан 07/19 дугаар удирдамжийн дагуу Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2023 оны 09 дүгээр сарын 08-наас 2023 оны 09 дүгээр сарын 15-ыг дуустал хугацаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Ажилтан албан хаагчдын амралтын хуваарийг нэгдүгээр улиралд багтаан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.2-т “Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтын саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Бараа материалын тайланг зарлага болгохдоо анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайлангаар зарцуулж Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах.

3. Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу зарцуулах.

4. Эдийн засгийн ангиллын зөрүү хийдэг байдлыг таслан зогсоож, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын ажил гүйлгээг хийх.

5. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, бараа материалыг зарлага болгохдоо анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайлангаар зарцуулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 05-ны өдрийн 347

642312084

тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөрчлүүдийг арилгах талаар төлөвлөгөө гаргаж зөвлөмжийн биелэлтэй хамт ирүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Хяналт шалгалтаар тогтоосон акт, өгсөн зөвлөмжийг хугацаанд биелүүлж хариуг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэхийг Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Р.Гантулга, Нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нар т хариуцуулав.

Шалгалтаар тогтоосон актын төлбөрийг хугацаанд нь барагдуулж, илэрсэн зөрчлийг арилгаагүй зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасан арга хэмжээ авч ажиллахыг анхааруулсугай.

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ **Б.БАТ-ЭРДЭНЭ**

